



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ТӨА-2025/022/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/167
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль нь Шилэн кабелийн 20Мбит/сек хурдтай интернэт болон Wi-fi цацагч төхөөрөмжийг Мобинет ХХК-тай хамтран ашиглалтад оруулж, 2024 оны 9 дүгээр сард шилэн кабельд бүрэн холбогдсон байна. Цахим системд суурилсан номын сангийн пос төхөөрөмж, англи хэлний хичээлийн Pearson, математикийн хичээлийн Eduten системийг нэвтрүүлж, цахимаар сурах орчныг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль нь гүйцэтгэлийн үнэлгээний индексийн 3 дугаар түвшнээр үнэлэгдсэн тул Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/389 дүгээр тушаалаар гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын санхүүжилтэд 24,298.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

412503147

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>152,985,585.24</u>	<u>262,745,695.10</u>
	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	117,732,484.06	193,514,153.72
312	Банканд байгаа бэлэн мөнгө	117,732,484.06	193,514,153.72
3121	Төгрөг	117,732,484.06	193,514,153.72
31211	Төрийн сангийн харилцах	117,732,484.06	193,514,153.72
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>35,253,101.18</u>	<u>69,231,541.38</u>
351	Түүхий эд материал	134,000.00	134,000.00
35130	Эм боох материал	134,000.00	134,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	-
354	Хангамжийн материал	35,119,101.18	69,097,541.38
35410	Бичиг хэргийн материал	96,500.00	96,500.00
35420	Аж ахуйн материал	1,325,910.00	1,325,910.00
35450	Барилгын засварын материал	996,000.00	996,000.00
35470	Бусад хангамжийн материал	32,700,691.18	66,679,131.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>805,725,214.11</u>	<u>818,425,842.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>805,725,214.11</u>	<u>818,425,842.17</u>
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	<u>741,265,214.11</u>	<u>753,965,842.17</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	611,054,479.00	611,054,479.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(121,871,228.04)	(147,047,663.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,335,067.00	265,264,195.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,852,487.17)	(77,949,135.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,194,679.78	174,323,131.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,668,663.67	2,668,663.67
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,077,729.66)	(1,180,370.58)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	26,992,085.10	25,649,388.10
393	Биет бус хөрөнгө	<u>64,460,000.00</u>	<u>64,460,000.00</u>
39301	Программ хангамж	902,500.00	902,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(902,500.00)	(902,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,460,000.00	64,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>958,710,799.35</u>	<u>1,081,171,537.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	958,710,799.35	1,081,171,537.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	311,643,563.78	311,643,563.78
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	444,995,355.24	567,456,093.16
51210	Өмнөх үеийн үр дүн	444,995,355.24	444,995,355.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	122,460,737.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	202,071,880.33	202,071,880.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>958,710,799.35</u>	<u>1,081,171,537.27</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,228,828,177.10	1,829,603,116.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,064,577.10	85,556,516.80
120	Нийтлэг татварын бус орлого	62,064,577.10	85,556,516.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,064,577.10	1,995,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,386,080.00	1,995,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,648.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,527,849.10	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Үндсэн хөрөнгө/	-	47,150,376.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Бараа материал/	-	36,410,840.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,166,763,600.00	1,744,046,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,039,381,600.00	1,569,282,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,381,600.00	1,569,282,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	127,382,000.00	174,763,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	127,382,000.00	174,763,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,213,207,055.33	1,702,068,281.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,207,055.33	1,702,068,281.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,115,582,384.36	1,584,065,858.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	774,222,383.32	1,133,100,702.20
210101	Үндсэн цалин	545,908,008.15	744,167,362.39
210102	Нэмэгдэл	190,364,319.22	348,461,239.81
210104	Урамшуулал	37,950,055.95	40,472,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,439,705.00	138,891,354.37
210201	Тэтгэврийн даатгал	66,168,321.75	95,617,885.57
210202	Тэтгэмжийн даатгал	7,764,223.98	11,341,085.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,211,379.05	5,754,702.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,474,065.60	5,215,478.71
210205	Эрүүл мэндийн даатгал	14,821,714.62	20,962,202.69
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,453,929.03	148,903,676.83
210301	Гэрэл, цахилгаан	4,821,606.03	4,882,816.83
210302	Түлш, халаалт	107,961,799.00	140,350,336.00
210303	Цэвэр, бохир ус	3,670,524.00	3,670,524.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,130,640.00	17,229,670.77

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,994,300.00	1,547,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,335,727.01	142,940,454.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,791,548.00	40,797,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,165,400.00	14,128,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,378,779.01	88,014,254.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,624,670.97	118,002,423.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,696,600.00	95,142,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,743,500.00	79,348,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,953,100.00	15,793,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,928,070.97	22,860,123.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,928,070.97	22,860,123.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,621,121.77</u>	<u>127,534,834.92</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26,749,065.18	5,074,097.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,113,625.03	1,342,697.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	17,635,440.15	3,731,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(26,749,065.18)	(5,074,097.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(11,127,943.41)</u>	<u>122,460,737.92</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,169,300,328.00</u>	<u>1,746,041,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,536,728.00	1,995,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,536,728.00	1,995,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,536,728.00	1,995,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,386,080.00	1,995,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,648.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,166,763,600.00	1,744,046,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,039,381,600.00	1,569,282,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,381,600.00	1,569,282,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	127,382,000.00	174,763,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	127,382,000.00	174,763,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,184,924,236.32</u>	<u>1,615,353,027.34</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,184,924,236.32	1,615,353,027.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,299,565.35	1,497,350,604.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	774,222,383.02	1,133,166,316.37
210101	Үндсэн цалин	545,908,008.15	744,528,359.88
210102	Нэмэгдэл	190,364,318.92	348,165,856.58
210104	Урамшуулал	37,950,055.95	40,472,099.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,439,705.30	138,825,740.20
210201	Тэтгэврийн даатгал	66,168,321.75	94,374,752.85
210202	Тэтгэмжийн даатгал	7,764,223.98	11,184,386.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,211,379.05	5,744,319.08
210204	Ажилгүйдлийн даатгал	1,474,065.90	5,499,976.28
210205	Эрүүл мэндийн даатгал	14,821,714.62	22,022,305.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,453,929.03	148,903,676.83
210301	Гэрэл, цахилгаан	4,740,906.03	4,882,816.83
210302	Түлш, халаалт	107,961,799.00	140,350,336.00
210303	Цэвэр, бохир ус	3,751,224.00	3,670,524.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,662,600.00	17,229,670.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,994,300.00	1,547,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан			
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,668,300.00	15,681,970.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,520,948.00	56,225,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,018,548.00	41,646,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,502,400.00	14,578,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,624,670.97	118,002,423.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,696,600.00	95,142,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,743,500.00	79,348,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,953,100.00	15,793,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,928,070.97	22,860,123.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,928,070.97	22,860,123.17
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(15,623,908.32)</u>	<u>130,688,872.66</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,623,908.32)	75,781,669.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	133,356,392.38	117,732,484.06
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	117,732,484.06	193,514,153.72

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,663,563.78	202,641,240.69	154,049,030.38	668,353,834.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,663,563.78	202,641,240.69	154,049,030.38	668,353,834.85
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	(20,000.00)	-	25,764,554.97	25,744,554.97
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,643,563.78	202,071,880.33	444,995,355.24	958,710,799.35
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,643,563.78	202,071,880.33	444,995,355.24	958,710,799.35
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	311,643,563.78	202,071,880.33	444,995,355.24	958,710,799.35
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	122,460,737.92	122,460,737.92
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	311,643,563.78	202,071,880.33	567,456,093.16	1,081,171,537.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		117,732,484.06		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,862,925,400.00	1,647,400,107.17	215,525,292.83	88.4
УРСГАЛ ЗАРДАЛ	1,862,925,400.00	1,647,400,107.17	215,525,292.83	88.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,754,401,600.00	1,552,257,807.17	202,143,792.83	88.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,286,166,500.00	1,133,166,316.37	153,000,183.63	88.1
Үндсэн цалин	843,269,700.00	744,528,359.88	98,741,340.12	88.3
Нэмэгдэл	397,656,100.00	348,165,856.58	49,490,243.42	87.6
Урамшуулал	45,240,700.00	40,472,099.91	4,768,600.09	89.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,771,000.00	138,825,740.20	21,945,259.80	86.3
Тэтгэврийн даатгал	109,324,200.00	94,374,752.85	14,949,447.15	86.3
Тэтгэмжийн даатгал	12,861,700.00	11,184,386.94	1,677,313.06	87.0
ҮОМШӨ-ний даатгал	6,430,900.00	5,744,319.08	686,580.92	89.3
Ажилгүйдлийн даатгал	6,430,900.00	5,499,976.28	930,923.72	85.5
Эрүүл мэндийн даатгал	25,723,300.00	22,022,305.05	3,700,994.95	85.6
Байр ашиглалттай холбоотой зардал	171,763,800.00	148,903,676.83	22,860,123.17	-
Гэрэл цахилгааны зардал	5,397,300.00	4,882,816.83	514,483.17	-
Түлш халаалтын зардал	161,366,500.00	140,350,336.00	21,016,164.00	-
Цэвэр бохир усны зардал	5,000,000.00	3,670,524.00	1,329,476.00	-
Эд хогшил худалдан авах зардал	3,000,000.00	3,000,000.00	-	-
Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,526,500.00	33,731,673.77	2,794,826.23	92.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,547,700.00	1,547,700.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,978,800.00	32,183,973.77	2,794,826.23	92.0
Бараа үйлчилгээний бусад зардал	96,173,800.00	94,630,400.00	1,543,400.00	98.4
Бараа үйлчилгээний бусад зардал	81,566,000.00	80,051,500.00	1,514,500.00	98.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,607,800.00	14,578,900.00	28,900.00	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,523,800.00	95,142,300.00	13,381,500.00	87.7
Бусад урсгал шилжүүлэг	108,523,800.00	95,142,300.00	13,381,500.00	87.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,730,000.00	79,348,500.00	13,381,500.00	85.6

Төв аймгийн Заамар сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан				
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,793,800.00	15,793,800.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,746,041,900.00	1,723,181,776.83	-	98.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,569,282,800.00	1,569,282,800.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,569,282,800.00	1,569,282,800.00	-	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	174,763,800.00	151,903,676.83	-22,860,123.17	87.0
Орон нутгийн төсвөөс	174,763,800.00	151,903,676.83	-22,860,123.17	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,995,300.00	1,995,300.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,995,300.00	1,995,300.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	117,732,484.06	-117,732,484.06	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	193,514,153.72	-93,514,153.72	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	39	39	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	26	26	-	100.0
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	618	587	31	95.0
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1	1	-	
Төрийн өмчит ЕБС	1	1	-	

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

3.1 Аудитаар нийт 77,896.1 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс 77,896.1 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд цалин хөлсний зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайланд 42.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	42.5					1	42.5				
Тайлант онд ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайланд 86.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	86.3					1	86.3				
Худалдан авсан 54,907.2 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа ажил үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан.	1	54,907.2					1	54,907.2				
Тайлант онд ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайланд 86.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	22.9					1	22.9				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 69 нэр төрлийн нийт 59,291.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй байна.	1	-							1	-	1	-
Дүн	5	77,896.1	0	-	0	-	4	77,896.1	1	-	1	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шалгагдагч байгууллага нь 2017 онд батлагдсан НБББББ-ийг мөрдөж байна.	1	-					1	-				
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 2 иргэн байгууллагын 5,710.2 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	-					1	-				
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 2 байгууллагын 5,309.9 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	-					1	-				
Дүн	3	-	0	-	0	-	3	-	0		0	-

